

**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН
ЗАХИРАМЖИЙН 2021 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН БИЕЛЭЛТ**

2021 оны 11 дүгээр сарын 30

Багануур дүүрэг

№	Ирсэн огноо	Батлагдсан огноо	Дугаар	Биелэлт
1	2021.06.18	2021.06.16	А/477	<p>Засгийн газрын 2021 оны 118 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/477 дугаар захирамжийн хүрээнд халдвар хамгааллын дэглэмийг баримтлан байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулж дараах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Ажилтнуудыг ажлын байранд нэвтрэхээс өмнө биеийн халууныг хэмжиж, гарыг халдваргүйжүүлж, ажлын байранд хүний гар хүрэх газрыг 2 цаг тутамд ариутгаж, өдөр бүр 3-4 удаа агаар сэлгэлт хийж, 7 хоногт нэг удаа их цэвэрлэгээ хийх ажлыг зохион байгуулж байна. - Иргэдийн зорчих хөдөлгөөний мэдээллийг бүртгэх QR кодыг иргэдийн орох хэсэгт ил харагдахаар байршуулан хэрэгжилтэнд шууд хяналт тавьж байна. - Ажилтан албан хаагчдад айл хэсэхгүй, зочин урихгүй, гэр-ажил маршрутаар зорчих чиглэл өгч байна. - ЭМЯ-наас бэлтгэсэн коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх талаарх зөвлөмж, сэрэмжлүүлэг, зурагт хуудсыг байгууллагын цахим хуудсаар дамжуулан иргэд олон нийтэд түгээж байна. 10 дугаар сарын байдлаар 20 мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулаад байна. <p>Цар тахалтай холбогдон гарсан бусад шийдвэрүүд, үүрэг даалгаврын хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллаж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Нийслэлийн Онцгой комиссын 2021.10.15-ны өдрийн 668 дугаартай албан бичгээр өгсөн чиглэлийн дагуу Дельта хувилбарын тархалт нэмэгдэж байгаатай холбогдуулан 10 дугаар сарын 18-ны өдрийн даргын зөвлөлийн хурлаар түрээслүүлэгч байгууллагад коронавирусын халдвар ихсэж, ажилтнууд халдвар авах эрсдэл өндөр гэж үзэн 0-12 насны хүүхэдтэй, гэрээсээ ажиллах хүсэлтэй албан хаагчдыг цахимаар ажиллуулахаар шийдвэрлэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. - НОК-ын Шуурхай штабын 2021.11.15-ны өдрийн 18 дугаар хурлын тэмдэглэл, 11.16-ны өдрийн 717 дугаартай албан бичиг, Багануур дүүргийн Онцгой комиссын 2021.11.19-ний өдрийн 367, 11.22-ны өдрийн 371 дугаартай албан бичгээр өгсөн чиглэлийн дагуу албан хаагчдыг ковид-19

			<p>халдварын эсрэг дархлаа сэргээх нэмэлт тунд хамруулах арга хэмжээг авч мэдээг хугацаанд нь хүргүүлэн ажиллаж байна.</p> <ul style="list-style-type: none"> - НОК-ын 2021.11.24-ний өдрийн 723 дугаартай албан бичгээр өгсөн “Коронавируст халдварын эсрэг дархлаа сэргээх нэмэлт тунгаар вакцинжуулах үйл ажиллагааг эрчимжүүлэх төлөвлөгөө”-ний 1.1, 1.2 дахь заалтын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. - Ажилтнуудыг 3 дугаар тунд хамруулах ажлын хүрээнд хамрагдвал зохих нийт 10 ажилтнаас 3 ажилтан хамрагдаад байна. - Спутник вакцин тариулсан 2 ажилтанд 3 дугаар тунд ямар вакцин сонгох, үр дүнг яаж харгалзах тухайд Эрүүл мэндийн төвөөс тодорхой зөвлөмж ирүүлэхгүй байгаа тул тухайн иргэд хүлээнэж байна. - Үлдсэн ажилчид 9-10 дугаар сард ковид халдвараар хүндэвтэр өвчилж, одоогоор сэргээн засах эмчилгээ хийгдэж байгаа бөгөөд эмчийн зөвлөмжөөр 3-р тунд хамрагдана.
--	--	--	---

ХЯНАСАН:

"БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛТ ТЕХНОЛОГИЙН ПАРК"
ОНӨТҮГ-ЫН ДАРГА

Ч.ЭЛБЭГСАЙХАН

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
ЗАХИРГААНЫ АЛБАНЫ
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



(Handwritten signature)

Э.ЭНХЗАЯА